

Манмин Мэдээ

№ 38 2013 оны 9 сарын 1

24 орноос ирсэн 530 гаруй эмч нар Бурханы агуу эрх мэдэлт хүч чадлын гэрч нар болсон юм!

WCDN-ний 10 дахь удаагийн Олон Улсын Христэд итгэгч Эмч нарын их хурал Мексикт боллоо



Дэлхийн Эмч Нарын Холбоо(WCDN)-ний төв нь Солонгосын Сөүлд хотод байдаг бөгөөд Христэд Итгэгч Эмч нарын байгууллага юм. Гишүүдийнхээ өсөлт хөгжил, нөхөрлөлийг дэмжиж, Амьд оршигч Бурханы хүчээр эдгэрсэн өвчинг гэрчлэн харуулж, Христчин эмч нарын үүрэг хариуцлага ажил мэргэжилд түлхүүр болохуйц сургаал номлодог. Зураг1: WCDN-ний 10 дахь удаагийн Олон Улсын Христэд Итгэгч Эмч нарын их хурал, 2. Зохион байгуулах хорооны дарга Даниел Фуэнтис докторын мэндчилгээ, 3. Гэрлийн Дуу дууны багийн урлагийн тоглолт, 4. Доктор Франциско Карлос Гомес Барбосагийн өвчний танилцуулга

2013 оны 6-р сарын 14-15 нд WCDN (Дэлхийн Христчин Эмч нарын Холбоо) – с зохион байгуулсан Олон улсын христчин эмч нарын их хурал Мексикийн Толука хотод боллоо.

Ойролцоогоор 350 эмч, мэргэжилтэнүүд 24 орноос ирж “Анагаах Ухаан ба Сүнслэг Байдал” гэсэн сэдвээр хуралд оролцлоо. WCDN-ний холбооны дарга доктор Гилберт Чей мэндчилгээндээ итгэл нэгт Христчин эмч нартаа Бурханыг хүлээн зөвшөөрдөггүй эмч мэргэжилтэнүүдийг энэхүү хурлаар дамжуулан Бурханыг таньж мэдүүлж ойлгуулаасай хэмээн уриалж байлаа. WCDN-ний тэргүүн, үүсгэн байгуулагч И Жей руг Тэргүүн пастор “WCDN- ний зорилго бол энэхүү эцсийн үед үй олон сүнснүүдийг аврах зайлшгүй шаардлагатай байгаа билээ. Тиймээс та бүхнийг өөрсдийн бүхий л хүч чадал, оюун ухаан, сэтгэл зүрхээ зориулан ажиллахыг хүсэн гуйж байна” гэж видео бичлэгээрээ дамжуулан хэллээ.

Мексикийн Зохион байгуулах хорооны дарга Даниел Фуэнтис доктор WCDN-с зохион байгуулж байгаа Олон улсын Христчин Эмч

нарын их хурал Латин Америкд анх удаа болж байгаа нь бидний хувьд нэр төрийн хэрэг болж байна гэж онцлон тэмдэглэв.

Энэ удаагийн хуралд анагаах ухаанд эмчлэгдэх боломжгүй долоон өвчтөнг залбирлаар эдгэрсэнийг эмнэлгийн хөдлөшгүй нотлох баримтаар гэрчиллээ. Холбооны дарга Гилберт Чей доктор цус алдах өвчтэй хоёр өвчтөнг итгэлээрээ И Жей руг пасторын залбирлыг авч эдгэрсэнийг мөн эмнэлгийн баримтаар нотлон харууллаа.

Мексикийн гоо сайхны мэс заслын мэргэжилтэн доктор Пастрана Фигуэроа охиныхоо өвчний түүхийг танилцуулав. Тэрээр охиндоо гоо сайхны мэс засал хийсний дараа охин нь гэнэт зүрхний булчингийн дутагдалд орж хүндрэн улмаар комонд орж үхэх аюултай болжээ Тэр үед И Жей руг Тэргүүн пасторын цаг хугацаа, орон зайг даван гарсан залбирлыг авч эдгэрсэн байна. Мөн Сингапурын гэр бүлийн эрүүл мэндийн мэргэжилтэн эмч Давид Юу докторын хүү нь шээсний замын өвчний улмаас гэдэсний саажилт, түгжрэл үүсч энэ нь хүндрээд

цусны идээд үрэвсэлтэй болж, шар өвчин туссан байна. Тэгээд И Жей руг Тэргүүн пасторын залбирлаар эдгэрсэн тухай гэрчилж байлаа.

Энэ мэт олон төрлийн баримтуудыг танилцуулсаны дараа олон асуулт хариулт ар араасаа үргэлжлэн эдгэрсэн хүмүүс ч ирж оролцсон. “Тусламжийн Гар” холбооны ерөнхийлөгч доктор Андрей Гасиоровский (Израиль) булчирхайн үрэвсэлтэй нэгэн хийлч эмэгтэй Бурханы хүчээр эдгэрсэн тухай танилцуулсан билээ. Үүний дараа хийлч эмэгтэй өөрийнхөө гэрчлэлийг ярьж хийл тоглон Бурханд алдар магтаал, талархалыг өргөлөө.

Үүнээс гадна эмч, мэргэжилтэнүүдийн итгэлийг өсгөсөн олон сүнслэг сургаалыг номлов. Пуэрто Рикогаос ирсэн Луйс Паз доктор, Перугийн Аполос Ланда доктор нар мэргэжил нэгт Христчин эмч нарт илтгэл тавьж, эмч нар хүний бие махбодийг төдийгүй сүнснийг ч мөн эмчлэх чадвартай байх хэрэгтэй гэдгийг онцлон тэмдэглэж байв.

Алвин Хванг доктор “Бурханы Эдгээгч хүчийг хүлээн зөвшөөрч ялгах зарчим” гэсэн тусгай сургаалыг номлов. Мөн түүнчлэн түүний охин

Лусиа Хванг Бурханы агуу их эрх мэдэлт хүчээр бугуйны булчин, шөрмөс шохойжих өвчинөөс эдгэрсэн баримтыг харуулж, ариун байдал болоод ойр дотно байдлын талаар ялгааг тайлбарлав.

Манмин Төв Сүмийн Урлагийн Зөвлөлийн “Гэрлийн Дуу” дууны багийн гайхамшигтай магтан дуу, бүжиг нь оролцогчдын сэтгэлийг хөдөлгөж, ивээл ерөөлийг дүүрэн өгч байлаа.

Хурлын дараа Даниел Фуэнтис доктор “Есүс Христ өчигдөр ч, өнөөдөр ч агуу гайхамшигуудаа үзүүлж, хүмүүс рүү хандсан агуу хайраа харуулсаар байна. Энэхүү хурал нь Бурханы хүчээр эдгээсэн эмнэлгийн баримтууд, сүнс сэтгэлийг сэргээсэн гайхамшигтай сургаалууд, Ариун Сүнсээр дүүрэн байж, Бурханыг алдаршууллаа” гэж хэлэв.

Энэ үеэр Коста Рикагийн Элчин сайд Фернандо Борбон Гватемал руу И Жей руг Тэргүүн пасторын залбирлаар уушигны хорт хавдраас эдгэрсэн гэрчлэл явуулж, хурлын эхний өдрийн хаалтын залбиралаар өргөл өргөв. Дараагийн 11дэх Хурал 2014 онд Болгарт явагдах болно.

Хайр Өөрийнхийг Эрдэггүй

“Хайр бол тэвчээртэй, энэрэнгүй юм. Хайр агаархдаггүй, бардам зан гаргадаггүй, ихэрхдэггүй, зохисгүй авирладаггүй, өөрийнхийг эрдэггүй, уурладаггүй, муутай тооцоо хийдэггүй.” (1 Коринт 13:4-5)



Доктор И Жей руг Тэргүүн Пастор

Цаг хугацаа өнгөрөх тусам хайр хөрч бусдын эрх ашгийг бодохоос илүү өөрийнхөө эрх ашгийг бодож байна. Хувийн эрх ашгийнхаа төлөө бяцхан хүүхдүүдийн иддэг хуурай хоолонд ч хортой бодис хийж, өөрийн улс орон нь хохирол амссан ч хамаагүй зөвхөн орон нутгийн зориулалтаар хийгдсэн технологитой зүйлсийг гадаад руу гарган худалдаж байна. Өнөөдөр маш олон хүн энэ мэт бузар жигшүүрт хэргийг огтхон ч эргэлзэж, санаа зоволгүйгээр хийж байна. Амин хувиа хичээх үзэл маш хурдан газар авч байгаа өнөө үед бид бүхэн цөхрөлтгүйгээр тууштай сүнслэг хайрыг эрэлхийлэх хэрэгтэй.

1. Сүнслэг хайр бол бусдын эрх ашгийг хайдаг

Өдөр тутмын амьдралаас харвал эхлээд өөрийн эрх ашгийг хардаг хүн үү, эсвэл бусдын эрх ашгийг эхлээд хардаг хүн үү гэдгийг мэдэж болдог. Хэсэг хүмүүс хамтдаа хооллохоор хоолоо сонгохоор боллоо гэж бодъё л доо. Энэ үед өөрийнхөө идэх дуртай хоолоо бусдад тулгах юм уу, бусдын хүслийг дагах мэт боловч миний дуртай хоол биш гэж сэтгэлдээ тавгүйтэн дургүйцдэг хүн байдаг. Нөгөө талаар өөрийнх нь дуртай хоол биш байсан ч бусдыгаа гомдоохгүйн тулд амтархан иддэг хүн ч байдаг.

Өөр нэг жишээ дурдъя. Хүмүүс аливаа нэг зүйлийг бэлтгэж байхад санал бодол зөрөлдөх үе бий. Энэ үед яадаг ч байсан өөрийнхөө бодлыг зөв болтол нь ятгахыг хичээдэг хүн байдаг бол өөрийнхөөрөө зүтгэдэггүй боловч бусдын санаа бодол өөрт огт таалагдахгүй хүн ч бас байдаг. Мөн хичнээн өөрийнх нь санаа илүү дээр байсан ч бусдын саналыг сонсож тэдний гаргасан саналыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэн дагадаг хүн ч бас байдаг.

Үүнтэй адил хүн бүрийн сэтгэлд хэр их хайр байгаагаас шалтгаалаад үйл хөдлөл нь ч өөрчлөгддөг. Хэрэв үзэл бодлоос шалтгаалан зөрчилдөөн гарвал өөрийнхөө байр суурьнаас зүтгэж зөрүүдэлж, өөрийн эрх ашгийг бодож байгаа эсэхээ эргэж харах хэрэгтэй. Бие биендээ найр тавьж, бусдын эрх ашгийг бодвол эв нэгдлийг бий болгож чадна. Хайрлана гэдэг нь бусдад найрсаг хандаж өөрийн эрх ашгаас илүү бусдын эрх ашиг дээдлэхийг хэлж байгаа юм. Өөрийн эрх ашгийг эрэлхийлсэн тохиолдолд л эв нэгдэл хагалж байдаг. Хэрэв бид хэн нэгнийг хайрлаж л байгаа юм бол өөрийнхөөс илүү түүний эрх ашгийг бодож, бүх зүйлд түүний санаа бодлыг хүндлэн үзэж чаддаг байна.

Эцэг эхчүүд өөрсдөөсөө илүүтэйгээр хүүхдүүдэд сайн хоол өгч, сайн хувцас өмсүүлэхийг хүсдэгтэй адил бусдын эрх ашгийг дээдэлсэн хүн байвал Бурхан бидэнд хичнээн их баярлах болоо!

2. Бусдын эрх ашгийг эрхэмлэдэг Абрахам

Өөрийн эрх ашгийг бодолгүйгээр бусдыг эрх ашгийг дээдлэх нь өөрийгөө харамгүй золиослож чаддаг хайрын сэтгэлтэй адил юм. Үнэндээ өөрийн эрх ашгийг бодохгүй бол хор хохиролтой юм шиг мэдрэмж төрдөг. Гэвч итгэлийн нүдээр харвал тийм биш юм. Бусдын эрх ашгийг харвал Бурханы хүслийг дагаж байгаа учир Тэр бүхий л зүйлд тань хариулж, ивээл ерөөлийг харамгүй өгөх болно.

Библид Абрахам яг ингэж ивээл ерөөлийг авч чадсан тухай бичсэн байдаг. Эхлэл номын 13-р бүлэгт Абрахам болон түүний зээ дүү Лотын тухай гардаг. Лот хүүхэд байхдаа ааваасаа өнчирч Абрахамыг аав шигээ бодож дагадаг байв. Лот нь Бурханы хайрыг хүртсэн Аврахамаар дамжуулан илүү их ивээлийг авах болсон юм. Тэд хоёулаа мал хөрөнгө, алт мөнгөөр элбэг хангалуун амьдарч байсан учраас тэдний малчдын хооронд малаа услах, бэлчээрээ булаацалдах гэх мэтээр маргаан гардаг байлаа.

Абрахам гэр бүлүүдийн хооронд үүссэн маргааныг таслахын тулд салж нүүхээр шийдсэн. Тэр эхлээд Лотод сайн нутгийг сонгох эрхийг өгсөн. Эхлэл 13:9-д “Чиний өмнө энэ их газар байгаа биш үү? Чи надаас салж яваач. Хэрэв чамайг зүүн тийшээ явбал, би баруун тийшээ явъя гэв” гэсэн байдаг. Лот нь ус унд элбэг, бэлчээр нутаг сайтай Иорданы тал хөндийг сонгосон.

Абрахамын байр суурьнаас харвал

Лотоос илүү их ивээл авсан мөн түүний авга ах нь, нэр хүндтэй, насаар ч ахимаг байсан учраас түрүүлж сонголтыг хийх боломжтой байсан ч тэр тэгээгүй. Ямар ч эргэлзээгүйгээр өөрийнхөө эрх ашгийг бодоод хамгийн сайн газар нутгийг сонгон явж байгаа Лотод мууг санаагүй харин чин сэтгэлээсээ түүнд илүү сайн өөртөө таалагдаж, сэтгэлдээ нийцсэн газар нутгийг сонгоосой гэж бодож байсан учраас эв нэгдэлтэй байж чадсан юм. Эцэст нь тэр Бурханаас илүү их ивээл ерөөлийг авсан байна.

Бусдын эрх ашгийг дээдэлдэг Абрахам эд хөрөнгө болон эрх мэдлээрээ алдартай ойр улсын хаадуудын хүртэл хүндлэлийг хүлээж чадсан юм. Ийм сайхан сэтгэлтэй учраас Бурханы анд нөхөр гэж хүртэл нэрлэгдэж байсан. Бүх зүйлд Абрахам шиг өрөөлийн эрх ашгийг хайдаг хүн бусдын эрх ашгийг дагаж, тэдний сэтгэлийг сайн ойлгодог байна.

Хайртай хүмүүсээ хайрлана гэдэг баяр баярын дотроос хамгийн дээд баяр баясгалан, аз жаргал юм. Үзэн ядаж байгаа хүнээ хайрлана гэдэг хэцүү ч харин хайртай хүнээ хайрлах нь тийм хэцүү биш байдаг. Хайртай хүндээ хамгийн нандин, үнэ цэнэтэй зүйлээ өгөхдөө ч бид их аз жаргалыг эдэлдэг. Өгөх нь авсанаасаа илүү их аз жаргалтай байдаг. Тиймээс би та бүхнийг бүх зүйлийг өөрөөсөө илүүтэй Бурханд, сүм чуулгандаа, хөршдөө, эцэг эхдээ, ах дүүдээ, эхнэртээ, нөхөртөө, болон хүүхдүүдийнхээ эрх ашгийг дээдэлдэг Бурханы өгөх сүнслэг хайрыг авч чадвал Эзэний өгсөн аз жаргалаар дүүрэн амьдарч чадна гэдэгт итгэлтэй байна.

3. Өөрийн эрх ашгийг эрж хайдаггүй байх

Христчин амьдралаар амьдрах нь зарим талаараа гэр бүлийнхэн болон бусад хүмүүст хэцүү мэт санагддаг. Жишээлбэл мацаг барин залбирч байх үед ажил дээр хүч шаардсан ажил хийхэд жаахан ядрах, сүм чуулгантай холбоотой чухал үед гэр бүлдээ хангалттай сайн анхаарал халамж тавьж чадахгүй байх, гэрийн эзэгтэй бол сүмийн ажилд анхаарал тавиад гэрийн ажлаа орхигдуулаад байна, оюутан сурагчид сүмдээ хичээнгүй сайн яваад хичээл сурлагандаа анхаарахгүй байна гэх мэтээр шалтгаалаг.

Өөрөө ч сайн амарч чадахгүй, өөрийгөө бодохгүй дандаа л бусдын эрх ашгийг бодлоо гэж бодох боловч яг үнэндээ өөрийнхөө төлөө өөрийн эрх ашгийг хайж байгаа хэрэг юм. Бурханы ажилд идэвхитэй байсан ч бүх зүйлийг

хийчихсэн гэсэн үг биш юм. Өөрийн хийх дуртай ажлаа сайн хийх боловч хийх хэрэгтэй шаардлагатай ажлыг хийдэггүй.

Тиймээс бид бүх зүйлд өөрийн эрх ашгийг дээдлэхгүй байхын тулд Ариун Сүнсэнд найдах хэрэгтэй болдог. Ариун Сүнс биднийг үнэнрүү замчилдаг. Бид ямар ч нөхцөл байдалд Ариун Сүнсний замчлалыг дагаж чадвал юуг ч хийсэн Бурханы алдрын төлөө хийж, амьдарч чадах болно.

Ариун Сүнсний дууг хоолойг сонсож, Түүний замчлалын дагуу явбал зүрх сэтгэлийн бүхий л хорон мууг хаях хэрэгтэй болдог. Цаашлаад, зүрх сэтгэлдээ сүнслэг хайрыг бий болгож чадвал ямар ч нөхцөлд байдал мэргэн ухааныг авах болно. Бидний сүнс сэтгэл амжилтанд хүрсэний адилаар эрүүл мэнд болоод бүх зүйл маань амжилтанд хүрч, хүссэнийхээ хирээр итгэлээрээ ажиллаж чадна.

Бид Бурханы хүүхдээр хүлээн зөвшөөрөгдвөл өөрийнхийг бус өрөөлийн эрх ашгийг бодож, итгэдэггүй гэр бүлийнхэн болоод хөршүүдээ хүртэл хайрлах ёстой юм. Би шинэ гэр бүл болсон залуу хосууд ивээлийн залбирал авахаар ирэхэд нь “Бие биенийхээ эрх ашгийг дээдэлж, хүндэлсэн сайхан хосууд болох болтугай” гэж залбирч өгдөг. Өөрсдийн эрх ашгаа л бодоод байвал амар тайван гэр бүл болж чадахгүй шүү дээ!

Хайрт итгэгч та бүхэн хайртай хүмүүсээ хайрлаж тэдний эрх ашгийг бодох нь хамгийн их аз жаргал гэж би хэлсэн билээ. Гэвч Бурхан биднээс зөвхөн үүнийг хүсээгүй. Тэр биднээс бидэнд сайн хандаж тусладаг, хайртай хүмүүсийнхээ эрх ашгийг бодоод зогсохгүй бүр харин хор хохирол учруулдаг, хэцүү хүмүүсийг хүртэл хайрлахыг хүсдэг юм.

Хэрэв та харьцахад хэцүү, дургүй хүнтэйгээ уулзахаас зайлсхийж зугтах сэтгэлээр хандаад байвал танд одоог хүртэл өөрийн эрх ашгийг бодох сэтгэл байна л гэсэн үг юм.

Ямар нэгэн таагүй нөхцөл байдалд эсвэл өөрөөсөө огт өөр ааш араншинтай хүнтэй уулзсан ч үргэлж бусдын эрх ашгийг бодож, өөрийгөө золиослож чадаж байж л сүнслэг хайрыг авч чадна. Өөрийн санаа бодол, зүрх сэтгэлд таарахгүй байсан ч хайр болон золиослолоор өрөөлийн эрх ашгийг дээдэлж чаддаг сүнслэг хүн болохыг Их Эзэний нэрээр хүсэн ерөөе!

Монгол Манмин Төв Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
www.manmintv.org



Өөрийн сэтгэл зүрхээ шалга! “Би хир зэрэг сүнслэг сэтгэлийг өөртөө бий болгосон бэ?”

Бурханы хүсдэг сүнслэг сэтгэл болон махан биеийн сэтгэлийн ялгааг дөрвөн талаас нь тодорхойлсон байдаг. Та яагаад би хир зэрэг сүнслэг зүрх сэтгэлийг өөртөө бий болгосон бол гэж өөрийгөө шалгаж үзэж болохгүй гэж?

Хойрго ба хойш суух сэтгэл болон бусдаас илүү гарах гэсэн сэтгэл

Эндээс “Хойрго, хойш суух” сэтгэл гэдэг нь хүнд хэцүү ажил хариуцаж авахгүйн тулд хойш суух, хариуцлагаас зайлсхийсэн, барьцгүй, шийдмэг бус хойрго сэтгэлийг хэлж байгаа юм. Мөн даруу төлөв байж, өөрийнхөөрөө ч зүтгээд байдаггүй ч үнэнийг баримталдаггүй, тус нэмэр болсоныхоо төлөө хүлээн зөвшөөрөгдөхийг ч хүсдэггүй сэтгэлийг хэлдэг байна. Ийм хүмүүс нь зохисгүй боолын сэтгэлээр дандаа бусдыг бодож, үнэн дотор бусадтай эв нэгдэлтэй байхыг хичээх хэрэгтэй. Ингэж бусдад үйлчлэх зүрх сэтгэлтэй хүн цаг үргэлж аз жаргалтай, амар тайван байж чаддаг байна.

Харин эсрэгээр “Бусдаас илүү гарах” гэсэн сэтгэл нь өөрийн нэр болон хийсэн үйлсээ л гаргахын хүсэж, бусдаас илүү өөрийгөө хүлээн зөвшөөрөгдөхийг хүсдэг сэтгэл юм. Өөрийн үүднээс харахад хичээл зүтгэл болон магтуулах, сайшаагдах давуу тал бий гэж үздэг учраас магтагдах болон бусдаар хүлээн зөвшөөрөгдөхийг ихээр хүсдэг байна. Үнэхээр даруу зүрх сэтгэлтэй бол тэгж их хичээн зүтгэлээ ч хийх л ёстой зүйлээ хийсэн гэж боддог учраас бусдаас илүү гарна гэх байдал нь харин ч өөрт нь ичмээр, эвгүй сэтгэгдэл төрүүлдэг байна.

Үүнээс гадна зарим ажилд өөртөө итгэлгүй, хүчгүйн улмаас ажилдаа идэвхигүй хандах юм уу хойш суух тохиолдол бий. Энэ үед надад бусдаас илүү гарах гэсэн сэтгэл байхгүй гэж боддог ч өөрийн сайн хийж чадах, мөн ил гаргах зүйл тохиолдвол тийм махан биеийн сэтгэл нь илчлэгддэг. Өөрийнх нь хүслийн дагуу болохгүй бол сэтгэлд нь гүн суугдсан шинж чанар буюу бухимдах, гомдоллох, маргалдах зэргээр ил гардаг Тиймээс хичээн өөрийн зөв байлаа ч цаг үе болон нөхцөл байдлаас шалтгаалан өөрийн байр сууриа илэрхийлэх үе ч байна, зүгээр өнгөрүүлэх үе ч байдагийг ялгах нь чухал билээ.

Хүлээн зөвшөөрөх сэтгэл ба шалтаглах сэтгэл

Сүнслэг хүн бол зэмлэл, шүүмжлэл, зөвлөгөөг сонсохдоо өөрийн алдаа дутагдалаа хүлээн зөвшөөрч чаддаг байна. Ингэхдээ түүний зүрх сэтгэл нь өчүүхэн ч эмзгэлдэггүй бөгөөд харин ч түүний алдаа дутагдлыг нь хэлж өгсөн дарга ч бай, өөрөөс нь албан тушаал доогуур хүн ч бай ямар ч хүнд чин сэтгэлээсээ талархаж байдаг. Энэ бүгдийг өөрийнх нь сайн сайхны төлөө хэлсэн гэж үздэг учраас талархаж чаддаг юм. Бүр түүний талаарх санал шүүмжлэл нь буруу байсан ч тэр дарууханаар хүлээн авч, миний үйлдэл бусдад яагаад ингэж харагдав, яагаад бусдын хүндэтгэлийг хүлээж чадахгүй байна гэж бодон өөрийгөө эргэн нэг хардаг байна.

Үүний эсрэг махан биеийн хүн бол сануулга, зэмлэл, шийтгэл ирэхэд алдаа дутагдалдаа заавал тайлбар тавьж, учир шалтгаан гаргаж ирдэг байна. Тэр ч бүү хэл зөвлөгөө өгсөн, шүүмжилсэн хүнд муу санаж, дургүйцэн уурлаж, түүний буруу гэж боддог.

Сүнслэг хүн бусдын сайн талыг, хүчтэй, давуу талыг нь хардаг бол махан биеийн хүн бусдын сул талыг л хардаг тул сул дорой итгэлтэй хүн бүх хүчээ дайчлахыг хараад ч дутуу байна гэсэн хандлагатай байдаг. Мөн атаархалын улмаас өөрөөс нь чадвар муутай хүн магтагдах үед түүний сул тал нь л бодогдож, харагддаг ба давуу сайн талыг нь хүлээн зөвшөөрдөггүй.

Харин сүнслэг хүн бусдыг илүү сайн болгохыг хүсдэг бөгөөд, нэг сайн талыг нь ч гэсэн хүлээн зөвшөөрч, илүү чадварлаг, хүчирхэг болгож, сул талыг нь засдаг юм.

Ойлгож өгөх сэтгэл болон Өөрийн үүднээс бодох сэтгэл

“Ойлгож өгөх” гэдэг нь бусдыг сайн сайхнаар бодох, тэдний хүч чадварыг харж үнэлж өгдөг сэтгэлийг хэлж байгаа юм. Энэ нь бусдын дутагдалтай талыг хараад гоочлох бус тэдний зүрх сэтгэлээр бодож, яагаад ийм байгааг тэдний байр суурьнаас, тэдний нөхцөл байдлаас харж ойлгож өгдөг. Одоо хэдийгээр дутагдалтай ч Бурханаас ивээл ерөөл өгөгдөхөд зайлшгүй өөрчлөгдөх болно гэдэгт итгэж, ямар үед хүчээ зориулан, сайхан сэтгэлээр тайтгаруулж, туслахыг хүсдэг сэтгэл юм. Ингэж бусдыг сайхан сэтгэлээр сайн талаас нь ойлгож өгвөл бусад хүмүүс ч танд зүрх сэтгэлээ нээж, халуун дотно харьцаа үүсэх болно.

Зарим үед бусдыг ойлгож өгөх зүрх сэтгэл дутсанаас болж, буруу ойлголцох, санал зөрөлдөн, зөрчилддөг. Та бусдыг зөвхөн өөрийн байр суурьнаас бодож, өөрийн эрх ашгийг хайвал өрөөлийг хэзээ ч ойлгохгүй. Хүн бүр өөр хоорондоо зан араншин, авъяас чадвар, боловсрол, өссөн орчин нөхцөл, итгэлээрээ ялгаатай бөгөөд бусад хүмүүс ч бас тантай адилхан төгс биш гэдгийг ойлгох хэрэгтэй.

Сүнслэг зүрх сэтгэлтэй хүн бусдын алдаа дутагдлыг харалгүй, тэдний нөхцөл байдлыг сайхан сэтгэлээр ойлгож бодож чаддаг. Бусдыг өөрийнхөөрөө шүүн дүгнэхээс өмнө хамгийн түрүүнд тэдний зовлонг мэдэрч, тэдэнтэй хамт харамсан гашуудаж чаддаг байна.

Хэрэв та бусдаас болоод хэцүү байдалд ороод байна гэж боддог бол та хэзээ ч өөрийгөө бусдын оронд тавьж чаддаггүйг харуулж байна. Яг ингэж өөрийнхөө байр суурьнаас бодоод байвал та хүнд туслаж чадахгүй харин ч хэцүү байдалд орж, хүндрэл учруулах болно. Тиймээс ерөөл бусдыг тэдний өөрсдийнх нь байр суурьнаас ойлгож өгвөл танд ямар ч хүндрэл учрахгүй, эв нэгдэл ч хагалахгүй байх болно. Та Бурханы зүрх сэтгэл, хайрыг мэдэрч, бусдыг сайхан сэтгэлээр ойлгохыг хичээх үед хичнээн зовлон шаналал дунд байсан ч сүнслэг зүрх сэтгэлийг авч чадна.

Хувирамтгай сэтгэл болон хувирашгүй сэтгэл

Сүнслэг зүрх сэтгэлтэй хүн ганц удаа авсан ивээлийнхээ төлөө талархаж сэтгэл нь хувирашгүй байдаг. Үргэлж сэтгэлдээ хадгалан авсан ивээлээ түүнээс нь илүү хариулахыг хичээж “Энэ хэмжээний байхад болно” гэж боддоггүй ба өөрөө хүнд байдалтай үед ч, баяр жаргалтай үед ч үргэлж хувирашгүйгээр талархаж, Эзэнийг хайрлах сэтгэлээ үйлсээрээ үргэлж зогсолтгүй харуулсаар байдаг.

Эсрэгээр нь, махан биеийн зүрх сэтгэлтэй хүний сэтгэл нь хувирч, үйлс нь хүртэл өөрсдийнх нь эрх ашигт нийцэхгүй байвал ивээл авсаныхаа дараа хувирч өөрчлөгддөг байна. Тэд эхлээд ивээл авч баяр хөөрөөр дүүрч байх үедээ Бурханы өмнө ам тангараг өгдөг ч харин сүүлдээ албадлагын сэтгэлээр ханддаг болчихдог. Мөн түүнчлэн, зарим нь амласнаа биелүүлэхгүй зөрчсөнөөсөө болж, шалгалт, сорилтонд орох тохиолдол бий.

Сүнслэг хүмүүс илүү идэвхтэй үйлдэх сэтгэлтэй тул хувирашгүй байдаг. Тэдний эцсийн зорилго бол сүнслэг зүрх сэтгэлтэй болохын төлөө учир, тэдний үйл хөдөлгөөн тэр чигтээ үзэсгэлэнтэй дүр төрх болон сайхан сэтгэлээр аливаад ханддаг юм.

Магадгүй та өөрийгөө сүнслэг зүйлс рүү тэмүүлдэг гэдэг ч тухайн нөхцөл байдалд хойш суухаас илүүтэйгээр бусдын дээр гарах зантай хүн үү эсвэл, бусдыг ойлгож өгөхөөс илүүтэйгээр өөрийн байр сууринаас боддог эсэх, зэмлүүлэх үедээ сэтгэлдээ тавгүйтэж, чин сэтгэлээсээ шүүмжлэлийг нь хүлээн авалгүй элдэв тайлбар, шалтаг тоочдог эсэх, авсан ивээлээ хариульга гэсэн сэтгэл тань өөрийн эрх ашгаа хайх зангаас чинь болж хувирч байна уу гэдэг талаар өөрийн сэтгэлээ эргэн харахыг хүсье.

WCDN (Дэлхийн Христчин Эмч нарын Холбоо) нь эдгэшгүй өвчнийг Бурханы хүчээр эдгэрсэнийг эмнэлгийн хөдлөшгүй баримтаар гэрчилж, Бурханы гайхамшигт эрх мэдэлт хүчийг нотлон харуулдаг билээ. Бурхан амьд оршигч, Библи бол маргаангүй үнэн гэдгийг Бурхан амьд оршин байдаг гэдэгт эргэлздэг, үгүйсгэдэг хүмүүст анагаах ухааны бодит баримтаар харуулж, баталгаатайгаар нотлон харуулсан юм.




Дэлхийн Христчин Эмч нарын Холбоо Бурханы эрх мэдэлт хүчийг анагаах ухааны баримтаар нотоллоо



Өмнөд Солонгосоос ирсэн өвчтөн
 Өвчин: **Тархины цус алдалт**
 Илтгэгч: **Чей Юун сог Доктор** (Мэс засалч)



49 настай эрэгтэй өвчтөн. 2012 оны 11-р сарын 13нд мөсөн дээр хальгарч унаад толгойгоо гэмтээсэн. Урьд нь 1991 онд авто ослоос гэмтэл авч тархиных баруун талд гинтом (цус хуралт) үүсч хагалгаанд орж байсан.



Залбирал авахын өмнө тархины хатуу хальсан бүрхүүл дор цус хуралт харагдаж байгаа нь. Залбирал авсны дараа илрээгүй, харагдахгүй байгаа нь.

Тархины бичлэгээр үзвэл баруун талдаа хавирган сарны хэлбэртэй тархины хатуу хальсан бүрхүүл дор цус хуралттай болсон бөгөөд давтан үзлэгээр бүр муудсаар байсан боловч өвчтөн өөрөө мэдэж хийлгэхээс татгалзаж байлаа. Түүний өмнөөс эхнэр, охин хоёр нь И Жей руг Тэргүүн пасторын зуучлан залбирлыг авсан байв.

Гэвч эмнэлэгт хэвтсэнийхээ 7дах өдөр уушигны үрэвсэлтэй болж биеийн байдал нь улам муудсаар байлаа. Тэгээд гэр бүлийнхэн нь хэдийгээр итгэдэг гэсэн боловч Бурханы өмнө сүнсэлг итгэлгүй байсныхаа төлөө гэмшиж 2013 оны 1 сарын 1нд дахин И Жей руг Тэргүүн пастораас хүүхдүүд нь аавынхаа төлөө залбирал авсан байна. Залбирал авсанаас хойш 2 өдрийн дараа тархины цахилгаан бичлэг хийхэд нөгөө тархины хатуу хальсан бүрхүүл дор цус хуралт байхгүй болсон байлаа. Бурханы эдгээх хүч цаг хугацаа орон зайг даван гарч, энэ мэт олон өвчнийг яг л Библид бичигдсэнээр тэр ч байтугай өвчтөн өөрөө байхгүй үед залбирал авсан ч эдгээж байна.




Мексикээс ирсэн өвчтөн
 Өвчин: **Зүрхний булчингийн дутагдал**
 Илтгэгч: **Доктор Пастрана Жөү Манюэл** (Гоо сайханы Мэс засалч)



2011 оны 11сарын 14нд 19 настай охин гоо сайхны хагалгаанд орсон. Хагалгаа ямар нэгэн хүндрэлгүй сайн явагдсан бөгөөд хагалгааны дараах хүндрэл байхгүй байсан. Гэвч хоёр өдрийн дараа гэв гэнэт цусны даралт нь бууж, амьсгал нь унаж ухаан алдаад яаралтай эрчимт эмчилгээнд шилжсэн. Зүрхний булчингийн дутагдлын улмаас зүрхний цохилт буурсан. Эрчимт эмчилгээнд түүний биеийн байдал улам бүр муудсаар байсан. Энэ үед мэс засалчид түүнийг найдваргүй, амьсгал хураах магадлал маш өндөр байгааг хэлсэн.

А) Зүрхний эхогоор зүүн талын ховдол томорсон хүнд өвчтэй байх үе нь
 В) Дахин шинжилгээ хийсэнээс хойш зургаан өдрийн дараа зүүн ховдлын үйл ажиллагааны байдал



Энэ үед түүний амь нас дээсэн дөрөөн дээр байсан бөгөөд түүний гэр бүлийнхэн WCDN-ний Америк дах захирал Арманда Пинедагаар дамжуулан И Жей руг Тэргүүн пасторын залбирлыг авахыг хүссэн. Тэгээд тэд түүний цаг хугацаа орон зайг даван гарсан залбирлыг авч маш гайхалтайгаар 2011 оны 11сарын 21нд сүмийн мөргөлийн үеэр эдгэрсэн юм. Тэр охин бүрэн эдгэрээд эрүүл саруул болж эмнэлгээс гарсан байна.



Сингапураас ирсэн өвчтөн
 Өвчин: **Цусны идээт үрэвсэл, шарласан**
 Илтгэгч: **Доктор Давид Юу** (Гэр бүлийн эмч)



Давид эмчийн хамгийн бага хүү 2009 оны 10 сарын 14нд төрсөн. Долоохон хоногтой хүү нь маш өндөр халуурч, хэдэн өдрийн турш тогтмол өндөр халуурсаар байлаа. Тэгээд эцэг эх нь түүнийг хүүхдийн эмчид 2009 оны 11 сарын 30нд үзүүлжээ. Хүүхдийн эмч түүний хүүг шээс бэлгийн замын өвчтэй гэж оношлоод маш яаралтай эмнэлэгт хэвтүүлж дотроос нь венийн судсаар антибиотек эмчилгээ хийлгэх шаардлагатай гэж зөвлөжээ. Гэвч тэд ийм антибиотек эмчилгээ хийлгэхэд нас нь арай л дэндүү бага, өөр олон төрлийн хор уршигтай гэдгийг мэдэж байсан тул гэртээ эргэж ирсэн байна. Тэд Христчин хүмүүс болохоор Бурхан хүүг нь залбирлаар эдгээнэ гэдэгт итгэж байлаа.

Хоёр өдрийн дараа түүний хүү нь улам бүр цонхийж шар өвчин туссан байлаа. Түүний гэдэс нь цүдийж, маш их зовиуртай байсан. Сайн мэдээ тунхаглагч Вонг Пинг түүний эхнэр Манмин Сүмийн И Жей руг Тэргүүн пастортой холбогдож, түүнээс тэдний хүүгийн төлөө залбирал авахыг хүссэн. Залбирал авсан дараа хүүгийн халуун буурч, гэдэсний цүдгэр нь багасч, тэр анх удаа инээж байсан юм. Дахин нэг залбирал авсны дараа шарлалт нь байхгүй болсон.



2009 оны 12 сарын 18нд цус, шээсний шинжилгээ хийлгэхэд биеийн байдал хэвийн болсон байв. Түүний шээсний замын өвчин, цусний идээт үрэвсэл төгс эдгэрсэн байлаа. Ямар ч эм хэрэглээгүй залбирлаар төгс эдгэж, одоо эрүүл саруул хэвийн өсөж бойжиж байна.

Улаанбаатар Манмин Сүм

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:
 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:
 Г. Анхбаяр СМТ 976-91173712
 976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул,
 152-848 Солонгос Улс
 Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
<http://www.manmin.org/english>
www.manminnews.com
 e-mail: manminministry@hotmail.com
 Нийтлүүлэгч: Жаерок Лее
 Редактор: Геумсун Вин